



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2016 оны 3 сарын 04 өдөр

Дугаар A-65

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Улсын Их Хурлын 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 93 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл”-ын 2.1 дэх заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:


1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 5.7 дахь заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай.

“5.7. Банк нь энэ журмын 5.4 болон 5.6-д заасан хязгаарлалтыг хангаж ажиллана. Банк гадаад валютын эрсдэлийг үнэлэх дотоод аргачлал ашиглаж болох ба уг аргачлал нь энэ журамд тусгасан “Хамгийн их эрсдэлийн арга”-д суурилсан байна.” гэж.

2. Энэ тушаалыг 2016 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг бүх банкны Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Зах зээлийн газар (Ж.Батаа), Хяналт шалгалтын газар (Д.Ганбат)-т тус тус үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

14-0430